



Ч.САНГИДОРЖИЙН ОГТОРГУЙН СЭТГЭМЖ ЦУВРАЛ ПРЕЛЮДИ-Д ХИЙСЭН СУДАЛГАА

^аГ.Заяабат, ^бБ.Номинзул
^аМУБИС-Багшийн сургууль, багш, доктор Ph.D.;
^бМУБИС-Багшийн сургууль, багш, магистр

Холбоо барих зохиогч: zasaba@msue.edu.mn, nominzul@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2023.11.03

Хянагдсан: 2023.11.25

Зөвшөөрсөн: 2023.12.18

Хураангуй

Прелюди нь оршил, удиртгал гэсэн утгатай латин гаралтай үг бөгөөд ихэвчлэн зохиолын эхэнд танилцуулга болон бие даасан хэлбэрээр тоглогддог хөгжмийн бүтээл юм. Энэхүү бүтээл нь олон янзын дүр дүрслэл хэв маягтай байж болох бөгөөд үүгээрээ зохиолчийн бүтээлч илэрхийллийг өргөн цар хүрээтэй харуулж чаддаг. Ч.Сангидоржийн “Огторгуйн сэтгэмж” цуврал прелюди нь орчин үеийн аргаар бичигдсэн бөгөөд хөг эгшиглэгээний хувьд атональ буюу аль нэг дэвсгэр хөгт баригдаагүй. Мөн экспрессионист чиг хандлагатай бүтээл төдийгүй өвөрмөц хэмнэл, хурц илэрхийллээрээ онцлог зохиол юм. Энэхүү өгүүлэлдээ “Огторгуйн сэтгэмж” цувралын № 6, 14 прелюди-г жишээ болгон авч хөгжимдөх аргын хувьд юун дээр анхаарах хэрэгтэйг, хэрхэн сэтгэж хөгжимдөх тухай тайлбарлалаа.

Түлхүүр үг

Төгөлдөр хуур, прелюди, зохиол, хөгжимдөх арга, сэтгэлгээ

Удиртгал

Энэхүү судалгааны зорилго нь төгөлдөр хуурт зориулсан “Огторгуйн сэтгэмж” цуврал прелюди-г хөгжимдөх арга, сэтгэлгээ талаас нь судалж, зохиолын онцлогийг танин мэдэх бөгөөд уг асуултад үндэслэн дараах таамаглалыг дэвшүүлэв. Оюутан нь “Огторгуйн сэтгэмж” прелюди-г төгөлдөр хуураар хөгжимдөх чадварыг сайжруулахад чиглэсэн нь үр дүнтэй хэрэглүүр болно. Мөн мэргэжлийн ангийн оюутнуудын хөгжмийн хэмнэл, сонсгол, уран сэтгэмж, төсөөлөл хөгжих боломжтой гэж үзэж байна. Энэ судалгаа нь монголын хөгжмийн зохиолчдын төгөлдөр хуурын бүтээлүүдийн судалгаанд хувь нэмэр оруулахаас гадна төгөлдөр хуур хөгжмөөр хичээллэж буй оюутнуудад гарын авлага, эх хэрэглэгдэхүүн болох ач холбогдолтой.

Судалгааны арга зүй

Оросын хөгжмийн зохиолч, сурган хүмүүжүүлэгч, хөгжимчин А.Шёнберг “атональ болон 12 өргийн аргыг ашигласнаараа бусдаас ялгарч энэ нь бусад хөгжмийн зохиолчдод нөлөө үзүүлсэн байдаг” гэж үзсэн байна. Монголын хөгжмийн зохиолч Ч.Сангидорж 1960-аад оны дунд үеэс уран бүтээлийн гараагаа эхэлж олон арван дуу, ари, романсууд бичиж, симфони уран бүтээл болон найрал дууны томоохон бүтээлүүд тууривсан боловч “Огторгуйн сэтгэмж” цуврал прелюдиг зохиохдоо А.Шёнбергийн энэхүү арга зүйгээр бичсэн байна.

Ч.Сангидоржийн “Огторгуйн сэтгэмж” цуврал прелюди

Түүгээр ч үл барам дан хөгжмийн бүтээлүүд нь арвин их. Үүнээс төгөлдөр хуур, хийл, морин хийлд зориулж хэд хэдэн зохиолууд бичжээ. Түүний дан хөгжмийн зохиолууд нь бадрангуй, их эрч хүчтэй байдаг. Түүний уран бүтээл дундаас төгөлдөр хуурт зориулсан бүтээлүүд томоохон байр суурийг эзлэх ба энэ хөгжмийн бүхий л төрлөөр зохиолуудаа бичсэн байдаг. Ч.Сангидорж төгөлдөр хуурт зориулж I концерт, 10 гаруй сонат, 50 гаруй прелюди, скерцо, рапсоди, уран сэтгэмж, ноктюрн, серенета, вальс, “Ойн чуулга”, “Огторгуйн сэтгэмж” цуврал, хүүхдийн альбом, “Монгол ардын 32 дуу”, ардын дууны 60 гаруй найруулга, этюд зэрэг 200 гаруй бүтээл туурвисан нь хөгжмийн төрөл, хэлбэрийн хувьд ч, мэргэжлийн ур чадварын хувьд ч өндрөөр үнэлэгддэг. Дээрх зохиолуудаас төгөлдөр хуурт зориулсан III, IV, XI сонат нь өвөрмөц дуурьсал, хэмнэлийн эрчимлэг шинж, арвин баялаг өнгө будаг, бүтээлч эрэл, шинэлэг сэтгэлгээгээрээ онцгой билээ (Сангидорж. 2012. х.199). Энэхүү цувралд ч гэсэн энэ бүх зүйлүүд илэрхийлэгдсэн байгаа. Жишээлбэл энэ зохиолд тремело (дуржигнуулга) хагас өнгө их ашиглагдсан байдаг. Ялангуяа бага хоёрц их долооц гэх мэт зай нь хөгжмийн дүр төрхийг илүү тод болгож өгдөг. Хоёрц нь түгшүүртэй гунигтай бачимдсан өнгө аясыг тремело нь түгшүүрийг илтгэж байдаг. Хөгжмийн зохиолч үүгээрээ дотоод сэтгэлийн тэмцэл, зөрчилдөөнтэй байдлыг харуулж өгдөг. Энэ бол тухайн хөгжмийн зохиолчийн өөрийн онцлогтой шууд холбоотой. Орчин үеийн хөгжим бол уламжлалт арга барилыг эвдэж бий болсон. Ямар нэг сонгодог ойлголт ямар нэг загвараас татгалзаж ертөнцийг цоо шинээр харах зорилготой. Энэхүү зохиол нь орчин үеийн аргыг ашиглан бичсэн ба хөг эгшиглэгээний хувьд атональ буюу аль нэг дэвсгэр хөгт баригдаагүй байна. Үүгээр нь энэ зохиолыг орчин үеийн зохиол гэж хэлж болох ба экспрессионист чиг хандлагаараа XX зууны төгөлдөр хуурын урлагтай холбогдож байгаа юм.

“Огторгуйн сэтгэмж” цуврал прелюди-г хөгжимдөх арга, сэтгэлгээ

Энэ зохиолыг хөгжимдөхөд төгөлдөр хуураар суралцагчдаас уран сэтгэлгээг шаардах төдийгүй зохиолч энэ зохиолоороо юу хэлэх гээд байгааг баяжуулж хөгжимдөх хэрэгтэй байдаг. Төгөлдөр хуураар тоглогч нь өөрийн сэтгэлгээгээр зохиолыг илэрхийлэх боловч зохиолчийн тавьсан тэмдэглэгээг заавал илэрхийлж хөгжимдөх хэрэгтэй байдаг. Зохиолын утга агуулгыг илэрхийлэхийн тулд хөгжмийн өнгөн дээр нарийн ажиллах хэрэгтэй. Ингэхийн тулд зохиолд задлан шинжлэл хийж нэг бүрчлэн хөгжимдөж үзэх хэрэгтэй. Мөн орчин үеийн хөгжмийн

талаар судалж дуугаралтын онцлогийг хэрхэн төгөлдөр хуурт буулгасныг таньж мэдсэнээр зохиолын нарийн хэсгүүд дээр ажиллахад тус дэм болж өгдөг.

Жишээ нь: зохиолд акцент, сфорцандо, стаккатто, нон легато тэмдэглэгээ ихээхэн үүрэгтэй. Хэмнэлийн хурц байдалтай зохицож утга санааг илэрхийлж байдаг. Стаккатто-г хөгжимдөхдөө илүү хурц тод, акцентыг зарим үед нилээн хүнд хөгжимдөж өгснөөр зохиолыг илүү илэрхийлж чадна. Мөн сфорцандо-г зарим хэсгүүдэд дуулалттай зөөлөн авснаар зохиолын утга санааг гаргаж чадна. Нон легато–г гэхэд маш гүн гүнзгий зөөлөн тоглох хэрэгтэй байдаг. Эдгээр хэсгүүд дээр ажиллахдаа нюансыг анхаарах нь чухал.

№6 прелюди-н хувьд өвөрмөц дуурьсал болон өнгөний мэдрэмжээрээ ялгардаг олон хоолойн зохиол юм. Дээд хоолойн ми өнгө суурь давтамж нь болж өгдөг. Энэ зохиолыг тоглохдоо маш их өвдөж байгаа мэтээр төсөөлж гүн гүнзгий (нон легато) хөгжимдөх хэрэгтэй. Эхлээд аяар (p) эхэлж аажмаар чангарч бүр маш чангад (ff) хүрснээ буцаад аяар хөгжимдөх нь зохиолын утга санааг гаргахад тустай байдаг. Мөн голын хоолойг холбож тоглох хэрэгтэй. Миний бодлоор дээд хоолойн ми өнгө давтамж болж голын хоолойд аялгуу эгшиглэж байгаа. Үүнд мөн басс (аргил) хоолой суурь болохоос гадна гол аялгуунд хариултыг өгч байдаг. Нюанс болон хэмнэлийн хувьд айзам дотроо маш их өөрчлөлтүүд харагдаж байдаг. Жишээ нь: гурван айзам дараалан *dim*, *cresc*, *sf*, *accel*, *rit* гэх тэмдэглэгээ ажиглагддаг. Энэ нь сэтгэл зүйн олон дүр төрхийг илэрхийлж байна (Зураг № 2 үзэх).

Энэ нь жижиг хэсэг ч гэсэн дотроо нилээд зөрчилдөөнтэй байгааг харуулж өгч байна. Зохиолч энэ прелюдигээрээ өөрийнхөө дотоод сэтгэлийн шаналсан байдлаа шингээж өгсөн байдаг. Тиймээс энэ прелюди-г хөгжимдөхдөө дээрх хэсгүүд дээр ажилласнаар утгыг бүрэн дүүрэн илэрхийлж чадна. Энэ прелюди-г хөгжимдөх үед голын хоолойг сонсож сурах нь нилээд ур чадвар шаардана. И.С.Бахын олон хоолойн зохиолыг хөгжимдөхөд хоолой бүр дээр нарийн ажилладаг шиг энэ мэт нарийн онцлогуудыг анхаарч хөгжимдөх хэрэгтэй.

Бага есц зайгаар аялгуу эгшиглэх үед голын хоолойг холбож хөгжимдөхдөө баруун гарын 1-р хуруугаар нон легато-г илүү тод хөгжимдөх хэрэгтэй. Энэ хоолойг цааш нь тасралтгүй холбохын тулд дуурьсгуурыг ашиглах хэрэгтэй болдог. Дуурьсгуурын хувьд аялгуу болон хоолойн өөрчлөлтүүдээс шалтгаалж нарийн авах хэрэгтэй.

The image shows a musical score for the first system of the No. 6 Prelude, measures 7-11. The score is in G major and 3/4 time. It features a treble and bass clef. The right hand plays a melodic line with slurs and accents, while the left hand provides harmonic support with chords and moving lines. Dynamic markings include *sf*, *rit.*, *ff*, and *pp*. There are also performance instructions like "Ped." and "8va. 1".

Зураг 1 №6-р прелюди 7-11 айзам

№14-р прелюди-н хувьд хэмнэл маш чухал. Вальс хэмнэлтэй нилээд урагш тэмүүлсэн өнгө аястай. Ямар нэгэн зүйл рүү тэмүүлж тэрүүгээрээ тоглож наадаж байгаа мэт. Энэ зохиол нь Сангидоржийн өөрийн зан чанартай нилээд холбоотой. Ёжилсон, егөөдсөн, хошин өнгө аяс илэрхийлэгддэг. Энэ дүрийг илэрхийлэхийн тулд баруун гарын треллийг тодорхой хурц хөгжимдөхөөс гадна чанга аяарын ялгаа, хурц сфорцандо-г гаргаж өгөх нь чухал. Зохиолын хүчдэлийн тэмдгүүдийг зохиолын утга агуулгаас шалтгаалж нилээд ёжтой хурц өнгөөр тоглох нь зохиолын уур амьсгалыг бүрдүүлж өгдөг. Яг л хоёр хүүхэд бие биенээсээ нуугдаж хөөцөлдөж тоглож байгаа мэтээр төсөөлөх хэрэгтэй.

Вальс

Зураг 2 №14-р прелюди 1-14 айзам

Дуурьсгуурын хувьд вальс гэхэд 3-р доль дээр авах шаардлагатай байдаг ч энэ зохиол дээр харин ч авахгүй тогловол зохиолын дүр төрх илүү гарч өгдөг. Учир нь вальс ч гэсэн доод хоолой айзмыг дуустал эгшиглэж байдаг. Гараараа барихаас гадна дуурьсгуураар холбож өгөх хэрэгтэй.

Мөн доорхи хам эгшгийн акцентийг дуулалттай хөгжимдөж аччелерандо хийн сүүл рүүгээ татаж өгснөөр зохиолыг дүгнэж байгаа мэт, дараа нь буцаад эхнийхээ хэмнэл рүү татагдаж төгсдөг. Сүүлд дахин давтагдах хэсгийг хэмнэлийн хувьд эхнийхээс арай удаан хурц дүрээр хөгжимдвөл зохиолыг илүү сонирхолтой болгож өгнө.

Зураг 3 №14-р прелюди-н оргил хэсэг 54-72 айзам

Хурууны хуваарилалын хувьд энгийн. Гэхдээ доорхи хэсгийн хурууны хуваарилалыг зөв тавьснаар хурдан хөгжимдөхөд хялбар байх болно. Хурууны хуваарилал /аппликатура/-ын талаар Л.М.Седрамян “Төгөлдөр хуур тоглох арга барил техникийн асуудлууд” номондоо хурууны хуваарилалын зарчмуудын талаар ингэж бичсэн байдаг.

- Хурууны хуваарилалтыг сонгохдоо гарын хэмжээ: шууны өргөн, хурууны урт, тэнийлтийг анхаарах
- Хурдан хэмнэл шаарддаг хэсгүүдэд нэг хуруу олон давтагдахгүй байхад анхаарвал зохино.

Тухайн хурууны хуваарилалтын тусламжтайгаар алгыг тэнийлгэхээс зайлсхийх хэрэгтэй. Хэрэв зайлшгүй шаардлагатай бол буцааж хэвийн байдалд нь маш хурдан аваачих хэрэгтэй (Седрамян. 2016.- х.37).

Энэ зохиолын хувьд аялгууны онцлогоос шалтгаалж дээрх зарчмын 2 дахь хэсэгт анхааран хурдан хэмнэлд тохируулан өөрт эвтэйхэн хурууны хуваарилалыг сонгох хэрэгтэй. Эхлээд треллийг 2,3-р хуруугаар холбоотой хөгжимдөж бага багаар чангарч өгнө. Баруун гарын уруудаж буй хэсгийг 3,5,3,1,4,2/ 5,3,4,2,3,1-р хуруугаар хөгжимдөж, өгсөх хэсгийг 1,2,3 1,2,3 1,2,3 1,3,1-р хуруугаар, треллээ 2,3-р хуруугаар хөгжимдвөл илүү хялбар байна.

Судалгааны үр дүн

Нэгдүгээрт: Мэргэжлийн хөгжмийн ангийн оюутнууд төгөлдөр хуур хөгжмөөр “Огторгуйн сэтгэмж” цуврал прелюдийг тоглохдоо хурууны дугаар, штрихүүдийг анхаарч зөв тоглох ба зохиолчийн тавьсан тэмдэглэгээг заавал илэрхийлж хөгжимдөх хэрэгтэй байдаг.

Хоёрдугаарт: “Огторгуйн сэтгэмж” цуврал прелюдийг тоглохдоо зохиолын утга агуулга, нюансыг ойлгон мэдэрч, уран илэрхийллээр сэтгэн хөгжимдөх аргуудыг эзэмшсэн байх хэрэгтэй.

Дүгнэлт

Монголын хөгжмийн зохиолч Ч.Сангидорж энэхүү аргыг ашиглан “Огторгуйн сэтгэмж” цуврал прелюдигээ бичжээ. Тэрээр энэхүү зохиолоороо монголын төгөлдөр хуурын урлагт шинэ өнгө аясыг үлдээж чадсан төдийгүй орчин үеийн арга судалгаагаар дамжуулан өөрийн санааг илэрхийлж өгсөнд гол онцлог нь оршиж байна. Огторгуйн сэтгэмж прелюди-н хувьд өвөрмөц дуурьсал болон өнгөний мэдрэмжээрээ ялгардаг бөгөөд мэргэжлийн ангийн оюутнууд тоглоход тохиромжтой бөгөөд өөрийн уран сэтгэмжээрээ баяжуулан тоглоход тохиромжтой зохиол юм.

“Огторгуйн сэтгэмж”-ыг хөгжимдөх арга, сэтгэлгээний хувьд: Эхлээд орчин үеийн төгөлдөр хуурын урлагийн талаар судлаж зохиол бүтээлүүдтэй танилцаж энэ төрлийн хөгжмийг суралцагчдад сонсгоно. Тухайн зохиолын атональ болон 12 өргийн аргыг суралцагчид мэдсэнээр зохиолын нарийн онцлогуудыг ойлгосны үндсэн дээр хөгжимдөх арга зүйд суралцана. Суралцагчид энэхүү прелюди дээр ажиллахдаа зохиолын онцлогийг танин мэдэж, хөгжмийн өнгө болон штрих

нюансууд дээр нарийн ажиллах хэрэгтэй байдаг. Мөн төгөлдөр хуур хөгжмөөр уг зохиолыг хөгжимдөхдөө хурууны хуваарилалт болон дуурьсгуурыг зөв хуваарилах нь чухал байдгийг анхааран ажиллах хэрэгтэй. Энэ бүхэн нь суралцагчдад тухайн зохиол дээр ажиллахдаа түүнийгээ уран илэрхийлэлтэй хөгжимдөж сонсогчдод хүргэх нь чухал байдаг. Оюутнуудад тухайн зохиолын утга санааг ойлгуулж, хөгжимдөж сурахад сэтгэлийн мэдрэмж, уран чадварлаг хөгжимдөхөд чиглэгдсэн гэж дүгнэж байна.

Талархал

Тус судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд үнэтэй зөвлөмж өгсөн тус сэтгүүлийн баг хамт олонд талархлаа.

Ном зүй

- Долгорсүрэн, Д., Нарангоо, О. (2021). *Төгөлдөр хуур*. УБ. Адмон
- Жанцанноров, Н. (1996). Хөгжмийн онолын нэр томъёоны хураангуй тайлбар толь. УБ. Соёмбо Житомирский, Д.В., Раабен. Л.Н, (1984). *Музыка XX века*. Москва. Академи
- Нямсамбуу, Г. (1986). Нот бичлэгийн гарын авлага. УБ. Клоур притинг
- Оюунбадрах, Б. (2014). Төгөлдөр хуурын зохиолыг боловсруулах асуудал /С.Соронзонболдын концертын жишээнд/: УБ. Докторын ажил.
- Сангидорж, Ч. (2011). Зулай цагаан алтай. УБ. Хөх судар притинг
- Сангидорж, Ч. (2009). Хорин прелюди. УБ. Соёмбо
- Седрамян, Л.М. (2016). Төгөлдөр хуур тоглох арга барил техникийн асуудлууд. УБ. Соёмбо
- Самин, Д. К. (2005). Суут хөгжмийн зохиолчид. УБ.

Цахим

- https://en.wikipedia.org/wiki/20th-century_classical_music
- https://en.wikipedia.org/wiki/Expressionist_music
- https://www.ted.com/talks/brian_green_on_string_theory/transcript?language=mn
- https://www.free-scores.com/index_uk.php3
- [https://en.wikipedia.org/wiki/Prelude_\(music\)](https://en.wikipedia.org/wiki/Prelude_(music))

THE RESEARCH DONE IN CH.SANGIDORJ'S IMIGATION IN SPACE SERIES PRELUDE

G.Zayabat^a, B.Nominzul^b

^aPh.D., lecturer, Teachers school, MNUE;

^bMaster, lecturer, Teachers school, MNUE;

Corresponding author: zasaba@msue.edu.mn, nominzul@msue.edu.mn 

Abstract

A prelude, a latin word meaning introduction, that is a piece of music usually played as an introduction solo at the beginning of a piece. This work can have many different style, which can show the autor's creative expression on a wide scale. Ch.Sangidorjs series of preludes "Imigation in Space" was writing in a modern composition that was atonal and expressionist work in terms of performance and is distinguished by its unique rhythm and sharp expression. For my research work, I chose "Imigation in Space" prelude series analyzed on №6,14 as an example by the techniques of playing and how to imagine.

Keywords

Piano, prelude, composition, piano technique, Imigine
